



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2023 оны I улирал

ХӨТӨЛГӨӨ МОРЬГҮЙ ХОЛ ЯВДАГГҮЙ

ХӨТӨЛГӨӨ МОРЬГҮЙ ХОЛ ЯВДАГГҮЙ

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13 хувиар нэмэгдлээ. Хэдий эдийн засгийн салбаруудын сэргэлт идэвхжиж буй ч бизнесийн зээлийн чанаргүйдэл өндөр хэвээр байна.

Урд хөрш цар тахлын эсрэг баримталж буй бодлогоо суллаж, хил гаалийн нөхцөл байдал сайжирсан нь уул уурхай, тээврийн салбарын сэргэлтийг хурдасган эдийн засаг 7.9 хувиар тэлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Мөн нийлүүлэлт, логистикийн хүндрэл аажмаар арилж манай улсын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн түвшин буурч буй хэдий ч дэлхийн зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөө өндөр хэвээр байна.

Монгол Улсын хувьд банкны салбар нь эдийн засгийн салбаруудыг дэмжиж буй ганц салбар байгаа юм. Хэрэв цаашид гадаадын хөрөнгө оруулалт татаж бусад салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн “хөтөлгөө морьтой” болохгүй бол уул уурхайн салбар нь сэргэхээр эдийн засаг нь сэргэдэг, унахаар дагаад унадаг эдийн засгийн бүтэцтэй явсаар байх нь цаашид илүү их эрсдэлийг дагуулах болно.




Хилийн хязгаарлалт суларч, гадаад аялал жуулчлал аажмаар нэмэгдэж байгаа нь төгрөгийн хадгаламжийг буурахад нөлөөлөв.

Эдийн засгийн салбарууд аажмаар сэргэх болсон нь төгрөгийн хадгаламжийг өмнөх оны мөн үеэс 3 хувиар, валютын хадгаламжийг 1 хувиар буурахад нөлөөлөв.

Эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэлтэй иргэдийн харилцах нэмэгдэв.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Их наяд ₮



Онолын
тодорхойлолт

Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

-3%

2023 оны I
улирлын
гүйцэтгэл

2023 ОНЫ БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкууд өөрийн эх үүсвэрээр хүнсний болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгож байна.



Банкуудын зээлийн чанар хэвийн түвшинд байна.



Системийн нөлөө бүхий 5 банк хуулийн хугацаанд IPO-гоо амжилттай хийлээ. Мөн тэдний санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Тээвэр логикийн хүндрэл аажмаар арилж буй нь эдийн засгийн салбаруудын сэргэлтийг хурдасгажээ.



Дэлхий даяар бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт нь манай улсын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх суурь шалтгаан болж байна.



Инфляц алгуур саарч, ханш тогтворжиж эдийн засгийн тодорхой бус байдал буурч байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 он I улирал

Бодлогын хүү нэмэгдсэн хэдий ч банкны зээл өсөлттэй байна.


Банкууд эдийн засгийг дэмжих, салбарын сэргэлтийг хурдасгах зорилгоор иргэд, аж ахуй нэгжид өөрийн эх үүсвэрээр зээл олгосоор байна.

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.



+5%

Зээлийн үлдэгдэл дунджаар 5 хувиар өсөв.



Эдийн засгийн гол салбаруудын сэргэлтийг дэмжих зээлийг банкууд олгожээ.

Иргэдийн хэрэглээний зээлийн эрэлт өндөр хэвээр байна.
Худалдааны салбараас бусад эдийн засгийн салбарын зээл олголт нэмэгджээ.



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр олгосон зээл

15%

ӨСЖЭЭ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд 10 зээл тутмын нэг нь чанаргүй байна.


9.6%

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо


Зээлийн багцын чанар хэвийн түвшинд байна.

Карт болон авто машины зээлийн чанаргүйдэл бусад хэрэглээний зээлтэй харьцуулахад өндөр байна. Хэдий уул уурхайн салбарын сэргэлт хурдацтай байсан хэдий ч салбарын зээлийн чанаргүйдэл өндөр хэвээр байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн I улирал



Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.


Зээлийн хүү

17%

Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүүгийн өсөлт үргэлжилсээр байна.

Төв банкнаас гадаад, дотоод эдийн засгийн нөхцөлд үүсэж буй тодорхой бус байдлаас шалтгаалан бодлогын хүүг нэмэгдүүлсэн нь зээлийн хүү аажмаар нэмэгдэх суурь шалтгаан болсон.




Гадаад орчны тодорхой бус байдал, хэрэглээний үнийн өсөлтөөс шалтгаалан иргэдийн төгрөгийн хадгаламж буурсаар байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад валютын хадгаламж 84%-иар, валютын харилцах 39%-иар тус тус нэмэгджээ. Төгрөгийн хадгаламжийн бодит өгөөж инфляцаас шалтгаалан сөрөг байгаа нь иргэдийн төгрөгийн хадгаламж буурахад нөлөөллөө.

Банкны эх үүсвэр, жилийн бүрийн I улиралд

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Валютын хадгаламж

39%

НЭМЭГДЭВ

Банкны системийн долларжилт

Жич: Хадгаламж болон зээлийн хэдэн хувийг валютын эх үүсвэр болон зээл бүрдүүлж байгаагаар тодорхойлогддог.

Эх үүсвэрийн долларжилт


37%

байна.

Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Гадаад орчны тодорхой бус байдал, хэрэглээний үнийн өсөлтөөс шалтгаалан иргэдийн төгрөгийн хадгаламж буурчээ.

Гадаад орчны тодорхой бус байдлаас үүдэлтэй валют хадгалах, нөөцлөх сонирхол иргэдэд их байна. Түүнчлэн иргэд хадгалахаас илүүтэйгээр хэрэглэх сонирхол өндөр байна.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2023 он I улирал

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий банкуудын актив өсөв.

13%

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 4.7 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Банкны салбарын активын өсөлт үргэлжилсээр байна.

Хаан банкны актив 18%-иар, Голомт банкны актив 16%-иар тус тус өсжээ.

Банкуудын актив, жил бүрийн I улирал




2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Хаан банкны эх үүсвэр 1.6 их наяд, ХХБ-ны эх үүсвэр 1.2 их наяд төгрөгөөр тус тус өсжээ.

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн I улирал



2021	2022	2023
Хаан		
ХХБ		
Голомт		
Төрийн банк		
Хас		

Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр нэмэгдэв.

14%

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

16%


Банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж байна.

Банкууд эдийн засгийн голлох салбаруудын сэргэлтийг дэмжих хангалттай өөрийн хөрөнгөтэй байна.

Банкууд IPO амжилттай хийж өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж чадлаа.

Голомт, Хасбанк, Төрийн банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгджээ.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн I улирал




2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023	2021	2022	2023
Хаан			ХХБ			Голомт			Төрийн банк			Хас		

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт хэт өндөр хэвээр байна.

Банкуудын олгож буй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өсөлттэй байна. Голомт болон Хасбанкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт буурсан хэдий ч хөрвөх чадвар өндөр хэвээр байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн I улирал



2020 2021 2022

Хаан

2020 2021 2022

ХХБ

2020 2021 2022

Голомт

2020 2021 2022

Төрийн банк

2020 2021 2022

Хас

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж

40%

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН


2023 оны I улирал: Эдийн засгийн өсөлт 7.9 хувьтай гарлаа. Хил, гаалийн нөхцөл байдал сайжирч, тээвэр логистикийн урсгалыг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалтууд хийгдэж буй нь уул уурхайн салбарын сэргэлтийг хурдасган эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэнээр эдийн засаг өсөхөд чухал нөлөө үзүүллээ.

Төлөв байдал: Хэрэв цаашид Оюу Толгойн гүний уурхайн олборлолт, түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт эрчимтэй үргэлжилсээр байвал оны төгсгөлд эдийн засгийн нөхцөл байдал сайжрах эерэг хүлээлтийг бий болгож байгаа юм. Засгийн газраас үр ашиггүй зардлуудыг бууруулсан нь төлбөрийн тэнцэл дээрх дарамтыг бууруулж, ханш тогтворжих нөхцлийг бүрдүүлж байна. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын түвшин өндөр хэдий ч цаашид буурах төлөвтэй байна.

2022 оны эхний улиралд эдийн засаг 7.9 хувиар өсөв.

Хил, гаалийн нөхцөл байдал сайжирч, дэд бүтцийн ажлууд хийгдэж буй нь уул уурхайн салбарт сэргэлтийг авчирлаа. Уул уурхайн салбарын сэргэлт нь тээврийн салбарт эергээр нөлөөлж тээврийн салбарын сэргэлтийг бий болгов.

Үйлчилгээний салбар, тэр дундаа мэдээлэл, холбоо, худалдааны салбарын тасралтгүй өсөлт нь эдийн засаг тэлэхэд чухал нөлөө үзүүлсэн хэвээр байна.




Гадаад худалдааны тэнцэл эхний улиралд 1.8 тэрбум ам долларын ашигтай байна.

Нүүрсний экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.3 дахин, төмрийн хүдрийн экспорт 1 дахин нэмэгдсэн нь экспортын өсөлтөд чухал нөлөө үзүүлжээ. Импортын бараа бүтээгдэхүүний бодит хэмжээ өсөлтгүй хэдий ч гадаад зах зээл дэх бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан импортын хэмжээ нэмэгджээ. Оны эхний хагаст хөрөнгө оруулалтын зориулалттай импортын бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн нь импортын өсөлтийн ихэнх хувийг эзэлж байна.


Хил, гаалийн хязгаарлалт болон тээвэр логистикийн хүндрэл багассан нь экспорт нэмэгдэхэд нөлөөлжээ.



Хөрөнгө оруулалтын зорилгоор импортолж буй бараа бүтээгдэхүүний хэмжээ нэмэгджээ.



Экспортын нөхцөл байдал сайжирч худалдааны тэнцлийн ашиг түүхэн дээд хэмжээнд хүрлээ.




Төлбөрийн тэнцэл 79.6 сая ам.долларын ашигтай байна.

Төгрөгийн бодит ханш суларч манай улсын бараа, бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад хямдарч эхлэхтэй зэрэгцэн экспортын бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлсэн нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад чухал нөлөө үзүүлжээ.


Импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс улбаатай валютын гадагшлах урсгал буурахгүй байна.

Төгрөгийн бодит ханш чангарч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж эхэлжээ.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл ашигтай гарав.




Инфляц аажмаар буурч, хадгаламжийн бодит өгөөж эерэг болох боломжийг олгож байна.

Импортын шатахуун, хүнс, үйлдвэрлэлийн бусад чухал орцуудын үнэ өссөн нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин өндөр хадгалагдах гол хүчин зүйл болоод байна.

Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 18% - иар өссөн нь инфляцын түвшин өндөр байхад нөлөөлж байна.

Инфляц болон бодит хадгаламжийн хүү

Хувиар




Төсвийн тэнцэл 656.6 тэрбум төгрөгийн ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурч байна.


Эдийн засгийн салбаруудын сэргэлт, түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн нь төсвийн орлогын өсөлтийг дэмжлээ. Нөгөө талаас төсвийн үр ашиггүй зардлуудыг бууруулж байгаа нь төсвийн тэнцлийг ашигтай гарахад чухал нөлөө үзүүлж байна. Үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурч байна.

Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 30 хувиар нэмэгджээ.

ДНБ-д эзлэх хувиар



Нийт төсвийн зарлага өмнөх оны мөн үеэс 10 хувиар нэмэгджээ.



Төсвийн алдагдал буурчээ.

